



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1/37

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны “Журам батлах тухай” 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын 5 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 53 дугаар “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” тогтоол, 268 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа алба нэгжийн өмчлөл, эзэмшлийн талбай болон бусад эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах, зохион байгуулах, материалыг үнэлэх, дүгнэх үүрэг бүхий комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын

дарга: Т.Батжаргал Захиргаа, удирдлагын газрын дарга

Нарийн бичгийн

дарга: Б.Мөнхбат Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн

Гишүүд: Х.Баярмаа Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны дарга

Ц.Болдсүрэн Аж ахуйн тасгийн дарга

2. Эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох тогтоолын дагуу зохион байгуулж ажиллахыг комисс /Т.Батжаргал/-т даалгасугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



Б.АЛТАНЦОМ